

**ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ**

**БАТЛАВ**

**Л.НАСАНЦЭНГЭЛ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

Огноо: 2019.01.08


**СЭМҮТ-Д ТЭЭВЭР ШАТАХУУН, БАГАЖ ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: СЭМҮТ-д Тээвэр шатахуун, багаж техник хэрэгсэл  
худалдан авах**

**Төслийн дугаар: СЭМҮТ/201901002**

**Харьцуулалт/  
гэрээний дугаар: СЭМҮТ-ТЕ-2019/02**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА



2019 оны 01 дүгээр сарын 08  
СЭМҮТ-д Тээвэр шатахуун, багаж техник хэрэгсэл худалдан авах  
СЭМҮТ/201901002

**Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **СЭМҮТ-д Тээвэр шатахуун, багаж техник хэрэгсэл нийлүүлэх тухай** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

**Багц 1 Шатахуун худалдан авах -28.185.900 төгрөг**

**Багц 2 Эмнэлгийн багаж, хэрэгсэл худалдан авах -5,654,400 төгрөг**

**Багц 3 Цахилгааны ерөнхий шит худалдан авах – 12,800,000 төгрөг**

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50,000** төгрөгөөр **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ сайтаас** худалдан авч болно.

Үнийн саналыг **2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 10:00 цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ хаягаар** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 30 минутанд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагын байрны Сургалтын өрөөнд** нээнэ.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Эрүүл мэндийн яамны харьяа  
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв 208 тоот  
Нягтлан бодогч Э.Гэрэлмаа  
Утас: 99738817**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |      |   |
|---|------|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.  |
|   | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.   |
|   | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.  |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.  |
|   | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.   |
|   | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.   |

**8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1. <b>Үнийн санал</b></p> <p>2. <b>Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь</b></p> <p>3. <b>Улсын бүртгэлийн гэрчилгээ нотариатаар баталгаажсан, хугацаа дуусаагүй байх</b></p> <p>4. <b>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</b>  <i>Багц 1 Шаардлагатай тусгай зөвшөөрөл</i>  <i>Багц 2 Шаардлагатай тусгай зөвшөөрөл</i>  <i>Багц 3 Шаардлагатай тусгай зөвшөөрөл</i>  <b>Монгол улсын хуулийн дагуу татвараа төлсөн, өр үүсээгүй болох нотолгоо харъяа татварын байгууллагын тодорхойлолт байх</b></p> <p>5. <b>Сүүлийн 2 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан, эс гаргасан тухай шүүх, эрх бүхий байгууллагын тодорхойлолт байх</b></p> <p>6. <b>2018 оны 2-р улирлын санхүүгийн тайлан /баталгаажсан байх/</b></p> <p>7. <b>2018 оны ижил төстэй гэрээний хуулбар</b></p> <p>8. <b>2018 онд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй борлуулалтын орлоготой байх</b></p> <p>9. <b>Харилцагч банкны тодорхойлолт /10 сая төгрөгийн зээл авах боломжтой эсэх/</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ хаягаар ирүүлнэ.</b></p> <p>Огноо: <b>2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>СЭМҮТ, БЗД, 9 дүгээр хороо 50 дугаар гудамж</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>Удирдлагын байр, 2 давхар сургалтын өрөө</b></p> <p>Огноо: <b>2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b>Багц 1 Шатахуун худалдан авах</b></p> <p><b>Багц 2 Эмнэлгийн багаж, хэрэгсэл худалдан авах</b></p> <p><b>Багц 3 Цахилгааны ерөнхий шит худалдан авах</b></p>


Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Багц - 1 Шатахуун

№	Барааны нэр:	Үзүүлэлт
1	Дизель түлш	<ol style="list-style-type: none"> <li>1. Цетаны тоо 45-с багагүй байх</li> <li>2. Найрлагын бүрэлдэхүүн: <ul style="list-style-type: none"> <li>• 50 % нэрэгдэх температур 280°C -аас багагүй</li> <li>• 96 % нэрэгдэх температур 340°C -аас багагүй</li> </ul> </li> <li>3. 20°C дахь кинематик зууралдлага 1,8-5,0 мм<sup>2</sup>/с –аас багагүй</li> <li>4. Царцах температур: <ul style="list-style-type: none"> <li>• сэрүүн бүсэд - 35°C-с ихгүй</li> <li>• хүйтэн бүсэд - 45°C-с ихгүй</li> </ul> </li> <li>5. Булинггартах температур: <ul style="list-style-type: none"> <li>• сэрүүн бүсэд - 25°C-с ихгүй</li> <li>• хүйтэн бүсэд -35°C-с ихгүй</li> </ul> </li> <li>6. Битүү тигельд дөл үүсгэх температур 35°C-с доошгүй</li> <li>7. Ус, механик хольц, хүхэрт устөрөгчийн хэмжээ байж болохгүй</li> <li>8. Нийт хүхрийн хэмжээ I бүлэг 0,20 %-с ихгүй</li> <li>9. Меркаптаны хүхрийн нийт хэмжээ 0,01 %-с ихгүй</li> <li>10. 20°C дахь хувийн жин 860 кг/м<sup>3</sup>- ихгүй</li> <li>11. 100 м<sup>3</sup> түлшинд байх бодит давирхайн хэмжээ 25 мг-ихгүй</li> <li>12. Хүчиллэг чанар: 100 м<sup>3</sup> түлшинд байх КОН-ын хэмжээ 5 мг- ихгүй</li> <li>13. Иодын тоо: 100 г түлшинд байх иодын хэмжээ 5 мг- ихгүй</li> <li>14. Үнсжилт 0,008 % -ихгүй</li> </ol>
2	А 92 бензин	<ol style="list-style-type: none"> <li>1. ГОСТ: ТУ 38.001165-2003 байх</li> <li>2. Октаны тоо 83-аас багагүй</li> <li>3. Октаны тоо моторын аргаар 95-аас багагүй</li> <li>4. Найрлагын бүрэлдэхүүн: <ul style="list-style-type: none"> <li>• Буцлах температур 215 байх</li> <li>• 10% нэрэгдэх температур, 75 ихгүй, С<sup>0</sup></li> <li>• 50% нэрэгдэх температур, 120 ихгүй, С<sup>0</sup></li> <li>• 90% нэрэгдэх температур, 190 ихгүй, С<sup>0</sup></li> </ul> </li> <li>5. Нийт хар тугалганы хэмжээ 0,005 г/дм<sup>3</sup> ихгүй</li> <li>6. Нийт хүхрийн хэмжээ 0,05 %, ихгүй</li> <li>7. Усанд уусах хүчил шүлтийн хэмжээ байж болохгүй</li> <li>8. Ус, механик хольцын хэмжээ байж болохгүй</li> <li>9. 15 °С, хувийн жин кг/м<sup>3</sup> 770-аас ихгүй</li> <li>10. 100м<sup>3</sup> бензинд байх бодит давирхайн хэмжээ, мг, 5-аас ихгүй</li> <li>11. Хүчиллэг чанар: <ul style="list-style-type: none"> <li>• 100м<sup>3</sup> түлшинд дэхь КОН-ын хэмжээ, мг, 3-аас ихгүй</li> </ul> </li> <li>12. Бензолын хэмжээ 5 хувиас ихгүй</li> <li>13. Зэс хавтгайн туршилтанд хувирахгүй</li> <li>14. Өнгөгүй</li> </ol>

2. **Стандарт:** Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан, үйлдвэрлэгчийн баталгаа гаргуулсан, 2018, 2019 онд үйлдвэрлэгдсэн, шинэ байна.
3. **Баглаа, боодол:** Барааны чанар, стандартыг алдагдуулахгүй зориулалтын **EMKO** стандарт хадгалагдсан байна.
4. **Бараа хүргэх газар:** Эрх бүхий албан тушаалтан нийлүүлэгчээс очиж авна.
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**



**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
А 92 бензин	Үнийн санал авах баримт бичигт заасан тодорхойлолтын дагуу	9000	литр	Эрх бүхий албан тушаалтан нийлүүлэгчээс очиж авна.	2018.02.01	2020.01.31	
Дизель түлш	Үнийн санал авах баримт бичигт заасан тодорхойлолтын дагуу	4885.2	литр	Эрх бүхий албан тушаалтан нийлүүлэгчээс очиж авна.	2018.02.01	2020.01.31	

## 1. Барааны тодорхойлолт:

### Багц – 2 Эмнэлгийн багаж, хэрэгсэл

№	Барааны нэр:	Үзүүлэлт
1	Суурин даралтын аппарат	<ol style="list-style-type: none"> <li>1. Бүрэн автомат, хэрэглэхэд хялбар</li> <li>2. Цусны даралт болон зүрхний цохилтын утга дэлгэцэнд харагдана.</li> <li>3. Цусны даралт болон зүрхний цохилтын утга хэвлэгдэнэ.</li> <li>4. Үзүүлэлтийг хэвлэх цаасны хамт</li> <li>5. Аппаратны ханцуй нь ямар ч хүний булчинд таарна. / өргөн/</li> <li>6. Зүрхний хэм алдагдлыг мэдэрч мэдээлнэ.</li> </ol>

2. **Стандарт:** Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан, үйлдвэрлэгчийн баталгаа гаргуулсан, 2018, 2019 онд үйлдвэрлэгдсэн, шинэ байна.
3. **Баглаа, боодол:** Барааны чанар, стандартыг алдагдуулахгүй, хайрцаганд савласан, хагарч гэмтэхээс хамгаалсан байх
4. **Бараа хүргэх газар:** БЗД, 9-р хороо, 50-р гудамж, СЭМҮТ аж ахуйн склад
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** 2019.02.01-2020.01.31


### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Суурин даралтын аппарат	Үнийн санал авах баримт бичигт заасан тодорхойлолтын дагуу	12	ширхэг	СЭМҮТ Аж ахуйн склад	2019.02.01	2020.01.31	



# 1. Барааны тодорхойлолт:

## Багц – 3 Цахилгааны ерөнхий шит- 2 ш



№	Барааны нэр	Үзүүлэлт
1	<p>Цахилгааны ерөнхий шит /том/</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ерөнхий автомат-1ш</li> <li>• 200-ын автомат- 4ш</li> <li>• 160-ын автомат-12 ш</li> <li>• 63-ын автомат -1ш</li> <li>• ОПС автомат -1ш</li> <li>• Хайрцаг-1ш</li> <li>• Провод-18м</li> <li>• Газардуулга-1ш</li> <li>• ОО-н клем-1ш</li> <li>• Боолт, Төгсгөвч</li> <li>• Зэс шин-28м</li> <li>• Өнгийн изо-27м</li> <li>• Диод-3ш</li> <li>• Угсралт, суурилуулалт</li> </ul>	<p><b>• MNS5834 стандартыг хангасан байх</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ерөнхий автомат <ul style="list-style-type: none"> <li>• ВА 88-37 3р чадал 400-450 ампер байх</li> </ul> </li> <li>2. 200-ын автомат <ul style="list-style-type: none"> <li>• ВА 88-35 3р чадал 200-220 ампер байх</li> </ul> </li> <li>3. 160-ын автомат <ul style="list-style-type: none"> <li>• ВА 88-33 3р чадал 160-200 ампер байх</li> </ul> </li> <li>4. 63-ын автомат <ul style="list-style-type: none"> <li>• ВА 47-29 3р чадал 63-80 ампер байх</li> </ul> </li> <li>5. ОПС автомат <ul style="list-style-type: none"> <li>• ОПС 1 В- 4р байх</li> </ul> </li> <li>6. Хайрцаг <ul style="list-style-type: none"> <li>• Өндөр 1800-2000 см байх</li> <li>• Өргөн 800-900 см байх</li> <li>• Зузаан 600-650 см байх</li> <li>• Стандартын шаардлага хангасан байх</li> </ul> </li> <li>7. Провод <ul style="list-style-type: none"> <li>• 1*1,5 мм.кв байх</li> <li>• 1*6 мм.кв байх</li> </ul> </li> <li>8. Газардуулга <ul style="list-style-type: none"> <li>• Зэс утастай байх</li> <li>• Хэмжээ 10*7-10*8 байх</li> </ul> </li> <li>9. ОО-н клем <ul style="list-style-type: none"> <li>• Зэс утастай байх</li> <li>• Хэмжээ 10*7-10*8 байх</li> </ul> </li> <li>10. Боолт, төгсгөвч стандартын дагуу байх</li> <li>11. Зэс шин <ul style="list-style-type: none"> <li>• 3*30 7-9 метр байх</li> <li>• 3*25 6-8 метр байх</li> <li>• 3*15 15-18 метр байх</li> </ul> </li> <li>12. Өнгийн изо шаардлагатай хэмжээтэй байх</li> <li>13. Диод <ul style="list-style-type: none"> <li>• Шар, ногоон, улаан өнгийн гэрэлтэй байх</li> </ul> </li> <li>14. Угсралт, суурилуулалт <ul style="list-style-type: none"> <li>• Шийтийг угсарсан байх / холбогдох зардлыг тендерт оролцогч хариуцах /</li> <li>• Шийтийг СЭМҮТ-н байранд ирж суурилуулж өгөх /холбогдох зардлыг тендерт оролцогч хариуцах/</li> <li>• MNS 5644:2006 стандартын дагуу самбар хүлээн авах, хүлээлгэн өгөх акт үйлдэх</li> <li>• Баталгаат хугацаа 6 сар бас түүнээс дээш байх</li> </ul> </li> </ol>

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.


Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>30</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ



- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтонд заасан шаардлагыг нэг бүрчлэн хангасан байх, шаардлага хангаагүй барааг хүлээн авахгүй.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын хугацаа <b>365</b> хоног байна. Үйлдвэрийн доголдлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><p>Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>0</b><br>Алдангийн нийт дүн: <b>0</b>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____ (Тамга, тэмдэг)	_____ (Тамга, тэмдэг)
_____ (Гарын үсэг)	_____ (Гарын үсэг)
_____ (Албан тушаал)	_____ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид "бараа" гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]